



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 13 өдөр

Дугаар

A/281

Улаанбаатар хот

Тарваган тахал болон хүн, малын гоц
халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1064 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт байгалийн голомтот тарваган тахал болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчний халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 08 дугаар сарын 15-аас өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл дүүргийн 24 дүгээр хорооны Гүнт дэх байнгын ажиллагаатай хяналт шалгалтын цэгийг түшиглэн 24 цагаар хяналтын үзлэг, тандалт хийж холбогдох арга хэмжээг авч ажиллахыг дүүргийн Цагдаагийн газар (Б.Амгалан-Энх)-т, Чингэлтэй нэгдсэн эмнэлэг (Х.Ганцэцэг)-т, Мал эмнэлгийн "Содхан" ХХК-ийн захирал (Д.Баасанхүү) нарт, өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Онцгой байдлын хэлтэс (Б.Батбилэг)-т тус тус үүрэг болгосугай.

2. Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад холбогдох байгууллагын алба хаагчдыг хамруулж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, дадлага зохион байгуулж ажиллахыг дүүргийн Чингэлтэй нэгдсэн эмнэлэг (Х.Ганцэцэг)-т, байгалийн голомтот тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасаг (Б.Баярчимэг)-т тус тус даалгасугай.

3. Гүнтийн давааны хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хуваарийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Хяналт шалгалт зохион байгуулахад шаардагдах 5,540,000 (Таван сая таван зуун дөчин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т, гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр)-т тус тус зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010816